

“ДОРНОД МОНГОЛ - 2011” АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА

Д.ТҮМЭН¹, М.ЭРДЭНЭ², Д.ХАТАНБААТАР³,
Г.АНХСАНАА⁴, Н.В. ЦЫДЕНОВА⁵

¹МУИС, НШУС, Археологи-Антропологиин тэнхим, e-mail: tumen@num.edu.mn

²МУИС, НШУС, Археологи-Антропологиин тэнхим, e-mail: merdene@num.edu.mn

³ШУТИС, Түүх-Аялал жуулчлалын профессорын баг, e-mail: hb_parl@yahoo.com

⁴ССАЖ Яамны харъяа Соёлийн өвийн төв, e-mail: g.anhaa@yahoo.com

⁵ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Түвд, судлалын хүрээлэн
e-mail: tsydenova@mail.ru

Түлхүүр үг: Сүхбаатар аймаг, Түвшинширээ сум, Улаанзуух, Адгийн гол, Энгэрийн бууц, Хүннүгийн үе, Хүрлийн үе, Булины дурсгал

ТОВЧ АГУУЛГА: 2011 онд МУИС-ийн Археологи-Антропологиин тэнхимийн археологийн хээрийн судалгааны баг Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан сумдын зааг нутаг Дэлгэрхаан уулын өвөр хэсэгт орших Улаанзуух, Адгийн гол хэмээх газар орших хүрлийн үеийн цогцолбор дурсгалаас найман були, Энгэрийн бууц дах хүннү булины цогцолбороос гурван були, нийт 11 булиийг малтан судаллаа.

Малтлага судалгааны үр дүнгээс харахад Улаан зуух болон Адгийн голд орших хүрлийн үеийн булины дурсгалууд гадаад, дотоод байгууламж, олдвор, оршуулгын зан үйлээрээ адил байгаа ба энэ нь уг хоёр дурсгал нэгэн үеийнх болохыг харуулж байна. Эдгээр булины дурсгалууд нь манай орны хүрлийн үеийн түгээмэл дурсгалын нэг болох шоргоолжин (хэлбэрт), дөрөө хэлбэрийн булины соёлтой талийгаачийг оршуулах зан үйлийн хувьд (талийгаачийн тэргүүнийг зүүн тийш чиглүүлэн, түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл) адилсаж байгаа ч булины гадаад, дотоод зохион байгуулалт, булинд дагуул чулуун байгууламж үйлдсэн зэрэг онцлог шинжээр эрс ялгагдаж байна. Энэ нь хүрэл зэвсгийн үед Дэлгэрхаан уулын орчим бүс нутагт бие даасан шинжтэй соёлын нэгэн хэлбэр (Улаан зуухын хэв шинж) оршиж байжээ гэж үзэхэд хүргэж байна.

Одоогоор Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын өвөр Улаанзуух, Адгийн гол, Булгийн эх зэрэг гурван газарт төвлөрсөн, хүрлийн үед холбогдох, гадаад байгууламжаараа ижил нийт 420 гаруй були бүртгэгдээд байгаа ба цаашид энэ бүсэд орших хүрлийн үеийн энэхүү өвөрмөц дурсгалын малтлага судалгааг улам өргөжүүлэн булины цогцолбор болон түүний дагуул чулуун байгууламж хоёрын зан үйлийн холбоо, уг цогцолбор дурсгалуудыг үлдээгч хүн амын антропологи бүтэц, угсаа гарвал, нүүдэл суудал, уг дурсгалын газарзүйн тархалт зэрэг олон чухал асуудлуудыг гүнзгийрүүлэн судлах шаардлага урган гарч байна.

МУИС-ийн Археологи-Антропологиин тэнхимийн археологийн судалгааны баг 2008-2010 оны археологийн хээрийн шинжилгээний явцад Сүхбаатар аймгийн

Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын өвөр хэсэгт орших Цагаан элэг хэмээх газарт хадны сүг зураг, Энгэрийн бууцад хүннүгийн үеийн 167 булшны дурсгал, Улаанзуух, Адгийн гол, Булгийн эх, Энгэрийн бууц зэрэг хоорондоо холгүй орших гурван газарт хүрлийн үеийн, өвөрмөц гадаад байгууламжтай үлэмж тооны булш бүхий дурсгал илрүүлсэн болно. Дээрх дурсгалт газруудад орших булш тус бүрийн газарзүйн байршлыг GPS-ээр тогтоон, хэлбэр, хэмжээ, түүхэн он цаг болон фото зургийн баримтжуулалт хийсэн. Үүнээс гадна Энгэрийн бууц, Адгийн гол, Булгийн эх, Тогоотын голын сав орчмыг хамарсан нийт 100 орчим км² талбайд хайгуул хийж шинэ чулуун зэвсгийн ил дурсгалыг шинээр илрүүлэн хэдэн зуун чулуун зэвсэг түүвэрлэсэн болно. Эдгээрээс 2008-2010 онуудад Улаан зуухад орших хүрлийн үеийн бүлэг булшны дурсгалаас нийт 13 булш малтан судалж үр дүнг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэн олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл тавин хэлэлцүүлсэн билээ (Наваан нар, 2008; 2009, Түмэн нар, 2010, Хатанбаатар, 2010; Tumen 2011) билээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Улаан зууханд орших хүрлийн үеийн булшны дурсгалууд хэд хэдэн эгнээгээр цувран байрласан байдаг. Нэг эгнээнд өөр хоорондоо залгаа байрлах хэд хэдэн булш байх ба булш бүр дөрвөлжин хэлбэрийн намхан чулуун хашлагатай. Гэхдээ нэг эгнээний булшнууд нэгэн урт гонзгой дөрвөлжин хашлага хүрээтэй байгаа нь нилээд онцлог юм.

2010 оны хээрийн судалгаагаар Улаанзуухын булшны цогцолборын хамгийн баруун захад орших баруун хойноос зүүн урагш чигтэй цуварсан бүлэг булшнуудаас эхний долоон булш (Булш - 1, 2, 3, 3а, 4, 5, 6) нийт 7 булш, 2011 онд Улаан зууханд урд жил малтан судалсан цувраа булшнуудын зүүн залгаа хоёр булш (Булш-7 ба 8), мөн бөөн булштай оршуулгын газраас зайдуу орших 4 булш (Булш 21, 62, 63, 66), Адгийн голд хүрэл зэвсгийн үед холбогдох зэрэгцээ хоёр булш (Булш-21 ба Булш-23), Энгэрийн бууцад хүннүгийн гурван булш (Булш-20, Булш-141, Булш-147), нийт 11 булшийг археологийн зохих арга зүйн дагуу малтан судалсан болно.

Мөн Тогоотын голын зүүн эргийн неолитын үеийн чулуун зэвсгийн олдоц элбэгтэй 3 хэсэг газарт 1,5 х 1м, 2 х 3м, 2х 4м-ийн хэмжээтэй зүсэлтийн малтлага хийсэн болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


*СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМ, ДЭЛГЭРХААН УУЛ,
УЛААН ЗУУХАНД МАЛТАН СУДАЛСАН БУЛШНЫ ТОДОРХОЙЛОЛТ*

Улаан зуух 7-р булш

N 46° 39' 04.9" ДТД 1070 м
E 111° 51' 42.1" Алдаа 4 м

Уг булш нь 2010 онд малтан судалсан 6-р булшны зүүн талд 80 см зайтай орших бөгөөд түүнтэй чулуун чигжээсээр холбогдсон байв (Зураг 4, Зураг 18).

Булш баруун урдаас зүүн хойш чиглэсэн, 590x840 см хэмжээтэй, хавтгай чулууг хэвтээгээр давхарлуулан өрж гонзгой дөрвөлжин хэлбэр гарган үйлдсэн, гадаад байгууламж нь бусад булшнуудтай адил боловч өмнөх жилүүдэд малтан судалсан булшнуудаас хэмжээгээр том байлаа. Уг булшны зүүн буюу толгой талын чулуун хашлага бусад гурван талын хашлаганаас 50 см өндөр байв (Зураг 19). Цэвэрлэгээний явцад чулуун дөрвөлжин өрлөгийн хойд хананы гадна талаас хүний хавирганы ясны хугархай илрэв. Уг булшны чулуун хашлаганы дотор төв хэсгийн дараас чулуунууд анхны байрлалаа алдаж нэлээд хөдөлсөн шинжтэй байсан ба тэдгээрийг үе үеэр хуулан авах явцад 25 см гүнээс адууны шүд, бод малын чөмөгний яс, бог малын хавирганы ясны хугархай илэрч байлаа.



Зураг 1. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 7-р булш. Оршуулга


Түүнээс доош үргэлжлүүлэн малтахад бага насны бог малын (хурга, ишигний байж болзошгүй) эрүүний хугархай, чөмөг яс зэрэг зүйлс олдлоо. Булшны өнгөн хөрснөөс доош 60 см гүнд 166x50 см хэмжээтэй оршуулгын нүхний толбо илрэв. Булшны толбоны зүүн дээд гадна талд 15 см орчимд хүний эрүү, зүүн эгэм, хавирга болон сээрийн зарим нугалам зэрэг хүний биеийн дээд хэсгийн зарим яс илрэв. Булшны толбыг дагуулан доош малтахад хашлагын дээд ирмэгээс доош 110 см гүнд оршуулга илрэв. Талийгаачийн тэргүүнийг ялимгүй зүүн хойш чиглүүлж, түрүүлгэ нь харуулан тэнэгэр байдалтай оршуулжээ (Зураг 1). Толгой болон хүзүү, зүүн дал, сээрийн зарим нугалмаас бусад яснууд анатомийн байрлалаараа илэрсэн болно. Булшны толбоны зүүн хойд хананд мэрэгчдийн гаргасан нүх дагасан хүрэн бор өнгийн судал байлаа. Эндээс жижиг мэрэгчийн яс ихээр олдлоо.

Уг оршуулга нь ахимаг насны эрэгтэй хүнийх байлаа. Хажуу ханануудыг шалгах явцад хөл хэсгийн чулуун дороос 10 орчим ширхэг цагаан сувс илрэв (Хүснэгт 3).

Улаанзуух 8-р булш

N 46° 39' 04.5" ДТД 1066 м
E 111° 51' 41.6" Алдаа 4 м

7-р булшны зүүн залгаа байрлах булш бөгөөд хавтгай чулууг хэвтээгээр давхарлуулан өрж хийсэн 520x420 см дөрвөлжин байгууламж юм (Зураг 4, Зураг 18, Зураг 20). 7 болон 8-р булшны завсрын чигжээс чулуунуудыг гаргах явцад чигжээсний зүүн хэсэгт 30 см гүнээс бод малын шаантны хугархай, баруун буюу хөл талаас бод малын дунд чөмөгний дээд булуу, шаантны хугархай зэрэг хойлгын малын яс илрэв. Цэвэрлэгээний явцад чулуун өрлөгийн баруун хойд булангийн гадна талаас адууны хавирга ясны хугархай, баруун урд хэсгийн дараас чулуудын завсраас хоёр ширхэг хар, хүрэн өнгийн битүү самнаа хээтэй ваарны хагархай илрэв



(Хүснэгт 3, Зураг 3). Дөрвөлжин өрлөгийн баруун хойд булан 90 см орчим өндөр бөгөөд бусад булангуудаасаа илүү өндөр байлаа. Зүүн буюу толгой талын хашлага 76 см өндөр, зүүн урд булан 70 см бөгөөд уг булшны чулуун өрлөг баруунаас зүүн тийш намссан байдалтай харагдана.


Зураг 2. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзуух, 8-р булш. Оршуулга

Энэхүү булшнийг малтахдаа дөрвөлжин чулуун хашлагыг анхны байдлаар нь үлдээж зөвхөн дотор талын чигжээс чулуудыг үе үеэр зайлуулах замаар гүйцэтгэв. Дотор талбайн төв хэсэгт 20 см гүнээс бод малын чөмөгний яс илрэв. Хашлагын доторхи чигжээс чулуунуудыг хоёр үе гаргахад 46 см гүнээс хавтгай чулууг босоогоор өрсөн цист маягийн байгууламжийн дээд ирмэг цухуйсан болно. Булшны төв хэсэгт байрлах энэхүү чулуун хашлагын урт 140 см, өргөн 53 см байв (Зураг 2). Уг байгууламжийн толгой болон хөл талд хавтгай том чулууг хэвтээгээр хөндөлдүүлэн тавьсан байдалтай. Толгой талын хөндлөн чулууны урт 80 см, өргөн 29 см, хөл талын чулууны урт 100 см, өргөн 36 см байв.

Байгууламжийн зүүн буюу толгой талын хананы гадна талаас хар өнгийн ваарны жижиг хагархай олдov. Хашлагын дотор талд 40 см гүн малтахад хүний эрүүний ясны хагархай, нугалам болон ваар савны хагархай, адууны шүд зэрэг зүйлс илэрлээ. Хашлагын хойд ханыг нэг том хавтгай чулууг босгон хийсэн нь анхны байрлалаар хадгалагдсан байна.

Хөл болон баруун хойд буланд хашлага чулуу байхгүй байлаа. Талийгаачийн толгой, цээжин хэсгийн яс байхгүй зөвхөн хоёр гар, бүсэлхийн нугалмаас дооших

яснууд анхны буюу анатоми байрлалаа хадгалан үлдсэн байна (Зураг 2). Оршуулгын нүх азимутын 60° зүүн хойш чиглэсэн байна. Талийгаачийн ясны анатоми байрлалаараа үлдсэн хэсэг, ясны гадаргын хөгжил болон бусад шинжээр түрүүлгэ нь харуулан гарыг нь их бие дагуу тавьж, хоёр хөлийг агируулан оршуулсан эрэгтэй хүний оршуулга болох нь тод харагдаж байлаа. Хүний баруун хөлийн өсгий орчимд бог малын хоёр ширхэг эрүүний яс олдлоо. Уг булш эрт үед тоногдсон бололтой.



Зураг 3. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан үул, Улаанзүүх, 8-р булш. Ваарны олдвор

Дагуул чулуун байгууламж

Улаанзүүхад орших хүрлийн үеийн оршуулганд нэгэн эгнээ булшнуудын аль нэг хэсэгт дөрвөлжин, цагираг хэлбэрийн дагуул чулуун байгууламж байгаа нь энэхүү дурсгалын нэгэн өвөрмөц онцлог юм. Бид 2009 онд дөрвөлжин хэлбэрийн дагуул байгууламжийг малтан судалсан билээ (Наваан нар, 2009).

2010-2011 онд малтан судалсан баруун хойноос зүүн урагшаа чиглэн нэг эгнээгээр өөр хоорондоо залгаа шахуу байрлах найман (1, 2, 3, 3а, 4, 5, 6, 7, 8-р булш) булшны зүүн урд захын 7 ба 8-р булшны баруун урд залгаа байх цагираг хэлбэрийн дагуул байгууламжийг бид 2011 онд малтан судаллаа (Зураг 4, Зураг 20).

Уг байгууламжийн хүрээ 7 ба 8-р булштай залгаа хэсэгтээ 3 м өргөн бөгөөд баруун тийшээ тойрох тусмаа нарийссан, хамгийн нарийн хэсэгтээ дан эгнээ чулуун өрлөгтэй болж байлаа.

Уг дагуул байгууламжийг анхлан хийхдээ хавтгай чулуудыг хажуугаар нь босгож замын хашлага маягаар хоёр эгнээгээр хавригалуулан зоогоод, эгнээний хооронд жижиг чулуудаар чигжсэн болох нь тус дагуул байгууламжийн анхны байдлаа хадгалан үлдсэн дийлэнх хэсгээс харагдаж байлаа. Тус цагирган хэлбэртэй дагуул байгууламжийн диаметр 15-17.5 м, цагирагны хамгийн өргөн 8-р булштай холбогдсон хэсэгт 3.5 м байхад эсрэг тал нь хамгийн нарийн 1.2 м орчим байна. Энэхүү цагираг дагуул байгууламжийг бусад булштай ижил бор хүрэн өнгийн боржин чулуудаар хийсэн байх ба цагирагны гүн, чулуудын өнгө, төрөл зэргээр

түүнийг булшнуудтай нэгэн үед 1-8-р бүлэг булшийг дагалдуулан байгуулсан байж болохыг таамаглаж болохуйц юм. Булшны хөл талын ханатай шууд залгуулан цагираг хэлбэртэй чулуун дагуул байгууламж хийсэн нь булшны энэ хэсгийн чулуун дараасыг бусад талынхаас өндөр, шигүү болгожээ. Энэхүү дагуул чулуун байгууламжийн малтлагаас ямар нэг олдвор гараагүй бөгөөд иймд уг дагуул байгууламжийн ямар зориулалттай, тахилга тайлга болох эсэх нь эдүгээ тодорхой бус байна.




Зураг 4. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзуух, 7 ба 8-р булш, тэдгээрийн дагуул чулуун байгууламж

Улаан зуух 21-р булш

N 46° 39' 05.5"
E 111° 51' 44.6 "

ДТД 1071 м
Алдаа 5 м

Уул булш тус оршуулгын газрын 3 эгнээ булшны хамгийн зүүн эгнээний хойд захад бусдаас зайдуу оршино. 21-р булшны өнгөн хөрсөн дээрх байгууламж 710x710 см хэмжээтэй, хавтгай боржин чулуун дараас бүхий дугуйдуу хэлбэртэй харагдана. Эрт үед тонуулчид төв хэсгийн дараас чулуудыг булшны гадуур тараан хаяснаас булшны гадаад байгууламж эвдэрч хэлбэр нь дугуйдуу болсон бололтой (Зураг 5, Зураг 21). Чулуун дараасын төв хэсэгт дөрвөлжин хэлбэрийн чулуун өрлөг тодорхой харагдана. Бид уг булшийг 9x10 м хэмжээтэй талбайгаар цэвэрлэгээ хийхэд 20 см гүнд хавтгай чулууг хэвтээгээр давхарлуулан өрж үйлдсэн 440x380 см хэмжээтэй дөрвөлжин байгууламж гарлаа. Уг байгууламж нь Улаан зуухын бусад булшны бүтэцтэй адил байсан бөгөөд зүүн хойд талын хашлага чулууд харьцангуй өндөр хийгджээ.



Зураг 5. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзуух, 21-р булш

Чигжээс чулуудыг гаргах явцад уг байгууламжийн зүүн урд хананы гадна талаас улаан өнгийн нимгэн шавар ваарны амсрын хагархай илрэв (Хүснэгт 3.). Булшны дөрвөлжин байгууламжийн урд хэсгийн чулуудыг эх газрын хөрсөнд тултал цэвэрлэж, хөндлөн зүсэлтийн зураглал үйлдэв. Булшны ханыг хавтгай чулуудыг 3 үе хэвтээгээр өрсөн бөгөөд 48 см орчим өндөр байлаа. Булшны хананы гадна талаас хавтгай чулууг босгоор налуулан зоосон нь маш тодорхой харагдаж байв. Уг булшны дөрвөлжин байгууламжийн дотор талбайн төв хэсэгт 45 см гүнд дөрвөн том чулууг хажуугаар нь босгож авсны хана мэт байрлуулсан өрлөг илрэв. Толгой болон хөл талд нэг нэг урт гонзгой чулууг хэвтээгээр хөндлөн тавьж, хойд, урд ханын дагуу 2 чулууг ялимгүй хажуулдуулан зоосон нь оршуулгын нүхний хэмжээг тодотгож байна. Уг байгууламжийн хэмжээ гадна хэсгээрээ 2x0.8 м ажээ.

Толбыг дагуулан 30 см малтахад нүхний төв хэсэгт доошоо харсан байдалтай хүний гавлын яс, түүний доороос хүний хөлын яс цухуйж байна. Хүний зүүн хөлийн яс хөндөгдөөгүй байгаагаас үзвэл түрүүлгэ нь харуулан оршуулсан байжээ. Насанд хүрсэн эмэгтэй хүний оршуулга байна.

Улаан зуух 62-р булш


N 46° 38' 49.3"

ДТД 1081 м

E 111° 51' 32.8"

Алдаа 4 м

Улаан зуухын оршуулгын газрын баруун урд хамрын урд энгэрт дөрвөлжин булш хоёр, Улаан зуухын хэв шинжийн нэг булш, гадаад зохион байгуулалтаараа шоргоолжин булштай төстэй нэг булш, нийт дөрвөн булш оршино. Эдгээрээс сонгодог хэлбэрийн дөрвөлжин булш нэг, шоргоолжин булш хэлбэрийн нэг булшийг тус тус малтан судлав.



Зураг 6. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзуух, 62-р булш

Уг 62-р булш нь маш том хавтгай чулуудыг босоогоор зоож хашлага хийсэн өндөр чулуун хана бүхий булш байна (Зураг 6, Зураг 22). Хойд хэсгийн хашлага харьцангуй бүтэн үлдсэн. Баруун урд талын хашлага үгүй болсон. Талбайн төв хэсэгт хоёр том хавтгай чулууг хэвтээгээр тавьсан байсан нь анхны байрлалаасаа нэлээд хөдөлсөн бололтой харагдана. Хашлагын гадна хэсгээр жижгэвтэр чулуугаар чигжиж өрсөн нь хөл болон хойд хэсгийн хашлагын гадна хэсэгт хэвээр үлджээ. Хашлагын хэмжээ 4.5x3.5 м. Баруун хойд булангийн хөшөө чулууны өндөр 110 см, өргөн 70 см. Толгой хэсгийн хашлага чулууд нэлээд эвдэрч гадагш налан унасан байлаа. Булшны цэвэрлэгээг хашлагааас гадуур тал тал тийш 50 см-ээр тэлэн хийж,

зураглал үйлдсэний дараачаар хашлагын дотор малтлагыг үргэлжлүүлэв. Талбайн голд байх хоёр том чулууг гарган цэвэрлэгээг үргэлжлүүлэн 70 см-ийн гүнд хүрэхэд зүүн хойд зүг чиглэсэн булшны толбо илрэв. Булшны нүхний хөл хэсгийг 1.7х1.2 м хэмжээтэй том чулуугаар хөндлөн таглажээ. Булшны нүхний төв хэсгээс ваар савны хагархай болон амсрын хэсэг илэрч байв (Хүснэгт 3). Мөн 74 см гүнээс хүний нуруу, дунд чөмөг, тахилзуур, шилбэний яс эмх замбараагүй байдалтай илрэв. Энэ төвшинд булшны нүхний хэмжээ 70х180 см байлаа. Уг булшнаас 4 өөр төрлийн ваарны хагархай нийт 31 ширхэг илэрсэн болно. Булшны нүхний толгой хэсгээс жижгэвтэр амьтны чөмөгний их биеийг зориуд засаж янзлан хийсэн ясан эдлэл олдov. Эрт үед уг булш тоногдон сүйтгэгдсэн нь маш тодорхой байлаа.


Улаан зуух 63-р булш

N 46° 39' 17.0"
E 111° 52' 29.2"

ДТД 1080 м
Алдаа 4 м

Уг булш нь Улаан зуухын оршуулгын газраас зүүн зүгт 250 м орчимд байрлах хадтай намхан хамруудын урд энгэрт байрлана. Энэхүү 63-р булшны өнгөн хөрсний чулуун дараас 5.6 м диаметртэй бөгөөд дугираг хэлбэр гарган том чулуудаар хийсэн ажээ. Цагаргийн зүүн хойд хэсэг чулуугүй, сэтэрхий харагдаж байв (Зураг 6, Зураг 23). Уг булшны малтлагыг 7х7 м хэмжээтэй тэг татан өнгөн хөрсний цэвэрлэгээг хийсэн болно.

Малтлагын явцад талийгаачийн баруун шанааны хажууд үйсэн эдлэлийн үлдэгдэл илэрлээ. Хүний цээжин хэсгээс хоншоор ясны түүшний хэсэг олдov. Зүүн хөлийн шагайн гадна талаас хүний эгэм болон бусад жижиг ясны үйрмэгүүд илрэв. Талийгаачийн цээжний доороос хавтгай чулуу илэрсэн ба уг чулууг нас барагчийн доор дэвсэн оршуулсан бололтой. Хүний ясны хадгалалт маш муу байлаа.




Зураг 7. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул,
Улаанзуух, 63-р булш

Улаан зуух 66-р булш

N 46° 38' 51.5" ДТД 1083 метр
E 111° 51' 35.5" Алдаа 5 м

Энэхүү булш Улаан зуухын оршуулгын газрын зүүн урд хамрын өвөр бэлд оршино. Гадаад байгууламж урт гонзгой хэлбэртэй, сайтар ажиглан харвал шоргоолжин булштай төстэй байж болохуйц санагдана (Зураг 9, Зураг 23). Ялангуяа хойд хэсгийн дараас чулууд хашлага мэт харагдахаас гадна ялимгүй хотойн орсон шинжтэй. Уг булшинд 6х3 метр хэмжээтэй тэг татан малтлага хийлээ. Хашлага чулуудын гол хэсэгт малтлага хийх явцад төв хэсгээс нилээд том хэмжээний зузаавтар үнсэн давхарга, шатаасан малын ясны үлдэгдэл илэрч байгаад байгалын хад тулав. Үнсний үлдэгдлээс дээж авч буцаан булав. Тахилгын зориулалтаар үйлдсэн байгууламж бололтой.



Зураг 9. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул,
Улаанзуух, 66-р булш 66

Дараас чулуудыг бүгдийг гарган цэвэрлэгээ 50 см гүн хүрэхэд оршуулга илрэв. Нас барагчийг чанх хойд зүг хандуулан тэнэгэр байдалтай оршуулсан байна. Хүний гавал, баруун гар болон хөлийн яснууд хөндөгдөлгүй анатомийн байрлалаараа үлджээ.

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМ, ДЭЛГЭРХААН УУЛ, АДГИЙН ГОЛД МАЛТАН СУДАЛСАН БУЛШНЫ ТОДОРХОЙЛОЛТ


Дэлгэрхаан уулын урд шувтарга Донгойн талтай залгах тэгш дэвсэг дэнж орчмыг Адгийн гол хэмээх ба баруун доогуур нь гол урсаж байсан хуурай сайртай,

зүүн хойд талаараа Өвдөг, баруун талаараа Булгийн эх зэрэг газартай залгадаг ажээ. Голын зүүн дэнжийн тэгш дэвсгэ дээр 1500 м² орчим талбайд булшнууд тархсан байх ба дэнжийн харьцангуй өндөр хэсэгт булшны гол төвлөрөл байрлана. Адгийн голын эдгээр булшнууд нь гадаад хэлбэр, зохион байгуулалтын хувьд Улаан зуухын дурсгалуудтай адил байсан тул 2 булш сонгон малтлага судалгаа хийлээ.

Адгийн гол 21-р булш

N 46° 39' 05.5"
E 111° 51' 44.6 "

ДТД 1071 м
Алдаа 5 м



Зураг 10. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул,
Адгийн гол, 21-р булш

Адгийн голын зүүн дэнж дээр харьцангуй шигүү төвлөрсөн дөрвөлжин хэлбэртэй булшнуудын баруун захад баруун хойноос зүүн урагш чиглэсэн залгаа гурван булшны баруун хойд захын булшийг сонгон малтлага хийлээ (Зураг 10). Өнгөн хөрсөн дээр 9.5x9 м диаметртэй дугуй хэлбэртэй түүний гол хэсэгт дөрвөлжин хэлбэрийн чулуун өрлөгтэй бөгөөд 10x9 м хэмжээтэй тэг татан өнгөн хөрсний цэвэрлэгээ хийлээ.

Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад талбайн төв хэсгийн дараас чулуунууд нэлээд хөндөгдсөн байдалтай харагдаж байлаа (Зураг 10, Зураг 24). Дөрвөлжин

чулуун өрлөгийн зүүн талын хашлага чулууд харьцангуй анхны байдлаар бүтэн үлдсэн байна. Дөрвөлжин өрлөгийн дотор хэсэгт чигжээс чулуудыг зайлуулан 60 см гүнд хүрэхэд 2x0.9 м хэмжээтэй зүүн хойд зүг 70° чиглэлтэй хүрэн бор өнгийн оршуулгын толбо илэрлээ. Толбыг дагуулан малтлагыг үргэлжүүлэхэд булшны толбоны төв хэсэгт 20 см гүнээс хэсэг чулуу, хүний дунд чөмөгний хос яс, гавлын ясны хэсэг, хоёр ширхэг шүд зэрэг зүйлс илэрсэн ба 100 см гүнээс хүний хоёр шилбэ, өсгийн яснууд анатоми байрлалаар гарав. Шаант, тахилзуур, өсгий ясны байрлалаас харахад талийгаачийг түрүүлгэ нь харуулан оршуулсан болох нь тодорхой байна.

Адгийн гол 23-р булш


N 46 35 095

ДТД 1045тм

E111 49 075

Хэмжээ:4.6 x3.7м

Бүлэг булшны баруун хойд захад бусдаас зайдуу орших жижиг хэмжээний булшийг 23-р булш хэмээн урьд бүртгэсэн байна (Наваан нар 2008). Энэхүү булш нь хавтгай чулууг хэвтээгээр давхарлуулан дөрвөлжин хэлбэр гарган өрсөн хашлагатай бөгөөд малтлагыг 9x8 м хэмжээтэй тэг татан өнгөн хөрсний цэвэрлэгээ хийсэн болно. (Зураг 11, Зураг 25).



Зураг 11. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Адгийн гол, 23-р булш

Дөрвөлжин байгууламж буюу хашлагыг тойруулан чулуугаар чигжсэн нь уг булшийг дугариг хэлбэртэй мэт болгожээ. Дөрвөлжин хашлагын зүүн болон зүүн

хойд хананд гадна талаас нь хавтгай чулууг босоогоор налуулан зоосон нь Улаанзууханд малтсан булшнуудтай адил байлаа. Булшны дөрвөлжин хашлага байгууламж 4.9x3.6x 0.6 м. хэмжээтэй байв. Хашлагын дотор талбайн чигжээс чулууны зузаан 60 см орчим бөгөөд үүнээс доош 5 см шороон үе байлаа. 65 см гүнээс зүүн хойш чиглэсэн битүү чулуун дараас бүхий хүрэн өнгийн оршуулгын толбо илрэв. Булшны нүхийг хавтгай чулуугаар тагласан бололтой боловч анхны байдлаа алдан нэлээд хөдөлсөн шинжтэй байв. Оршуулгын толбыг дагуулан үргэлжлүүлэн 40 см орчим гүн малтахад нүхний зүүн хэсгээс маш муу хадгалагдан үлдсэн хүний шилбэний яс илрэв. Үүнээс доош байгалийн хөрс илэрч малтлагыг зогсоов. Нийт гүн 105 см болов.

*СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМ, ДЭЛГЭРХААН УУЛ,
ЭНГЭРИЙН БУУЦНЫ ХҮННҮГИЙН ҮЕИЙН ДУРСГАЛ*

Нутгийн тахилгат Дэлгэрхаан уулын ноён оргилын баруун урд урагш харсан аманд хүннүгийн үед холбогдох 150 гаруй булш байдгийг 1990-ээд оны сүүлээр археологич З.Батсайхан илрүүлэн хэд хэдэн булшийг малтан судалсан ажээ (Батсайхан 2002).

2008 онд “Дорнод Монгол” төслийн археологийн багийнхан уул оршуулгын газарт орших булшнуудыг тус бүрийн координатыг тодорхойлон нарийвчилсан бүртгэл, баримтжуулалт хийсэн болно (Наваан нар 2008). Энгэрийн бууцын хүннү булшнууд тус амны эхнээс адаг хүртэл тархсан байх ба гол төвлөрөл нь амны дунд хэсэгт байх ажээ. Эдгээр булшнуудаас газарзүйн байрлалаар амны эх, дунд, адаг хэсэг тус бүрээс нэг нэг булш сонгон малтлаа.


Энгэрийн бууц 20-р булш.

N 46° 37' 40.9" ДТД 1116 метр
E 111° 48' 17.3" Алдаа 5 м

Дэлгэрхаан уулын гол оргилын өвөр дор баруун урагш харсан Энгэрийн бууц хэмээх амны бараг эхэнд буюу оршуулгын газрын зүүн хойд захад зайдуу орших ба газрын хөрсөн дээр цөөн тооны чулуутай цагариг хэлбэрийн булш (Зураг 12, Зураг 26). Уул булшийг 7x6 м хэмжээтэй талбайгаар өнгөн хөрсийг цэвэрлэхэд 6.9 м диаметртэй цагирган хүрээ илэрлээ. Цэвэрлэгээний явцад дараас чулуудын өмнө хэсгээс улаан болон хар өнгийн вааран савны хагархай, бод малын ясны хэсгүүд илэрч байв. Булшны чулуун цагаргийн өргөн дунджаар 1.8 м.


Цагирган хүрээний төв чулуугүй хэсгийн диаметр 2.1 м орчим байна. Талбайн төв хэсгийн малтлагын явцад төмөр амгайн үлдэгдэл болон дэгээ маягийн төмөр эдлэлүүд, бод малын яснууд, вааран савны хагархай зэрэг зүйлс, 70 см гүнээс уртавтар төмөр хутганы хэсэг, юу болох нь тодорхойгүй төмөр эдлэлүүдийн үлдэгдэл, төмөр амгай, малын яс зэрэг зүйлс илрэв (Зураг 13, Хүснэгт 4). Өнгөн хөрснөөс доош 110 см гүнд ялимгүй баруун хойд зүг чиглэсэн 210 см урт, 70 см өргөн чулуун авс илрэв. Авсыг 150 см урт, 60 см өргөн хавтгай чулуугаар тагласан

нь анхны байрлалаараа байгаа бололтой гэмээр байв. Хөл талд хоёр давхар чулуугаар хашлага хийж түүний гадна талд 30 см өндөртэй хавтгай чулуу босгожээ.



Зураг 12. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга, 20-р бүлш

Хашлагын хөл буюу зүүн урд буланд нэг чулуу босгожээ. Чулуун авсны тагийг нээхэд давхар модон хашлагатай тоногдсон оршуулга илрэв. Авсны дунд хэсгээс хүний гавал болон бусад жижиг яснууд эмх замбараагүй байдалтай олдлоо. Чулуун авсны баруун хойт тал буюу толгой хэсгээс үйсэн эдлэлийн үлдэгдэл илэрлээ. Уг оршуулга маш их тоногдсон байх агаад модон шалтай байсан нь тодхон харагдана.



Зураг 13. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул.
20-р булшны олдворууд: Тайлбар: 1, 2, 3, 6 - Төмөр эдлэлийн үлдэгдэл, 4-5- Төмөр амгай, 7-
Төмөр урт хутганы үлдэгдэл, 8-10- ваар


Энгэрийн бууц 141-р булш

N 46° 37' 32.4"
E 111° 48' 17.1"

ДТД 1104 метр
Алдаа 4 м


Амны доод хэсэгт нэгэн том хэмжээний булшны зүүн хажууд байрлах жижиг булш. Уг булш нь цөөн тооны том чулуутай зууван дугуй хэлбэрийн дараастай байлаа (Зураг 14, Зураг 141). Дараасын хойд хэсгийн чулууд хөдөлсөн шинжтэй. Хойд зүгийг чиглүүлэн тэг татаж булшны өнгөн хөрсний цэвэрлэгээг 6x7 м хэмжээтэй талбайд хийв. Булшны төв хэсгийг дайруулан 20 см хэмжээтэй хамар үлдээн малтлагыг явууллаа. Цэвэрлэгээний явцад чулуун дараасын зүүн хойд болон баруун хэсгээс хүрэн өнгийн нимгэн ваарны хагархайнууд 6 ш илрэв (Зураг 15, Хүснэгт 4).

Булшны чулуун дараасыг авч малтлагыг үргэлжлүүлэхэд 58 см гүнд хойд зүг чиглэсэн хөл хэсгээрээ цөөн тооны чулуутай оршуулгын толбо илрэв. Оршуулгын толбоны өргөн 66 см, урт 200 см байлаа. Оршуулгын толбоны дагуу үргэлжлүүлэн малтахад ваар савны хагархай, хүний хурууны үе яснууд гарч байв. Малтлагын гүн 160 см хүрэхэд чулуун хашлага бүхий оршуулга илэрлээ. Нүхний хойд хэсгээс хүний эрүү, сүүж, бугалга, шуу, богтос яснууд болон модны үлдэгдэл илэрч байв. Хүний хөлийн яснууд бүтэн үлдсэн байгаагаас үзвэл талийгаачийн толгойг хойд зүг чиглүүлэн тэнэгэр байдалтай оршуулсан болох нь харагдлаа. Зүүн хөлийн гадна талаас модонд хадаж байсан ул мөр бүхий муу хадгалагдсан төмөр хадаасын толгой



Зураг 14. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга. 141-р булш

хэсэг олдлоо. Талийгаачийг чулуун хашлаганд оршуулсан байсан хэдий ч хашлаганы толгой болон баруун ханын зарим чулуу байхгүй болжээ. Хашлагыг дунджаар 80-70 см орчим урттай, 50-60 см орчим өргөнтэй чулуудыг ашиглан хийжээ.




Зураг 15. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга, 141-р булш. Ваарны олдвор

Энгэрийн бууц 147-р булш

Н 46° 37' 40.9"
Е 111° 48' 17.3"

ДТД 1116 метр Монголын үе
Алдаа 5 м


Амны зүүн доод хэсэгт орших дунд зэргийн хэмжээтэй чулуудаар үйлдсэн цагариг хэлбэрийн булш (Зураг 16, Зураг 27). Чулуун дараасны диаметр 5.7 м. Цэвэрлэгээг 7х6 м талбайгаар хийж гүйцэтгэв.



Зураг 16. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга, 147-р булш

Дараас чулууны өргөн 1.5 м, голын чулуугүй хэсгийн зай 3.2 м орчим байна. Чулуудыг зайлуулж хөндлөн зүсэлтийг үйлдсэний дараа талбайн төв хэсэгт 2х1.5 м хэмжээтэй малтлагыг явуулав. 70 см гүнд ялимгүй зүүн хойд зүг чиглэсэн оршуулгын толбо илэрлээ. Оршуулгын уг толбо 210х80 см хэмжээтэй байх агаад 1.7 м гүнээс толбоны хойд хэсгээс овоолон хаясан хүний яс илэрлээ.

Эдгээр ясан дундаас ясаар хийсэн зууван хэлбэрийн зүүлт илрэв. Үүнээс гадна бага насны хүүхдийн гавлын ясны хэсгүүд илэрч байв. 1.9 м гүнд толбоны хөл хэсгээс бод малын сээрний 3 ш яс, төв хэсэгт төмөр эдлэлийн үлдэгдэл, нимгэн ваарны хагархай илэрлээ (Зураг 17, Хүснэгт 4). Эндээс нийт 2 төрлийн 5 ш вааран савны хагархай илрэв. Маш их тоногдсон оршуулга байлаа.



Зураг 17. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга, 147-р булш. Ваарны олдворууд

СУДАЛГААНЫ ХЭЛЦЭМЖ

Хүрлийн үе

Булшны гадаад зохион байгуулалт: Улаанзуухан дах хүрлийн үеийн булшнууд гурван эгнээ байрлалтай бөгөөд бусад булшнууд уг гурван эгнээний зүүн хойт талаар тархан байрлана. Нэг эгнээнд байх булшнууд ерөнхий нэг урт гонзгой дөрвөлжин хүрээнд өөр хоорондоо залгаа байрлалтай байна. 2010 онд бид хамгийн баруун талын эгнээний хоорондоо залгаа орших 8 булшны эхний зургаан булшийг малтан судалсан ба (Түмэн нар 2010) 2011 онд уг эгнээний зүүн талын захын хоёр булш буюу 7, 8-р булшуудыг түүний дагуул чулуун байгууламжийн хамт малтан судаллаа. 7, 8-р булшнуудын гадаад зохион байгуулалт нь өмнөх жил малтан судалсан энэ эгнээний бусад булштай адил, харин 8-р булш хэмжээгээр энэ эгнээний хамгийн том нь юм.

Булшны зохион байгуулалтаас харахад хүнээ хөдөөлүүлэхдээ оршуулгын нүхээ ухаад, нүхийг тойруулан багавтар хавтгай чулуудыг 4-5 давхраар хэвтээгээр дөрвөлжин хэлбэрээр өрөөд, түүний гадна талаар том хавтгай чулуудыг түшүүлэн босгон хашлага хийж, хормойгоор нь жижиг хавтгай чулуудаар чигжин хөдөлгөөнгүй даруулдаг байсан ерөнхий зохион байгуулалт харагдаж байна. Ингэхдээ зүүн болон хойд талын хашлага бусдаас өндөр бөгөөд иймэрхүү зан үйл энд байх ихэнх булшинд тохиолдох түгээмэл хэлбэр болно. Үүнээс гадна Адгийн голд малтан судалсан 21 ба 23-р булшны гадаад дотоод чулуун байгууламж, оршуулгын зан үйл, вааран эдлэлийн хагархай зэрэг нь Улаанзуухын булшныхтай адил байна.

Монголын хүрлийн үеийн дөрвөлжин булшийг судалсан Г.П.Сосновский (1928)

1. Өндөр чулуун хашлагатай бөгөөд 4 буландаа гозгор чулуутай
2. Намхан дөрвөлжин чулуун хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараасаар хүрээлсэн
3. Талууд нь дотогш хотойсон хавтгай чулуун дараастай хэмээн 3 ангилаад эхний хэлбэр нь МЭӨ VI-III зуун, хоёр дахь хэлбэр нь МЭӨ III-II зуунд хамаарна гэж үзсэн ба (Сосновский 1941: 307-308) хожим 1.5 м хүртэл өндөр хашлага чулуу бүхий 4-р хэлбэр байна гэж үзжээ.

Ц.Төрбат Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Эрдэнэхайрхан ууланд малтсан хоёр булшны хэрэглэгдэхүүнийг урьд өмнө малтан судлагдсан дөрвөлжин булшны гадаад, дотоод зохион байгуулалт, зан үйлтэй харьцуулан үзээд Дөрвөлжин булшны соёл нь он цагийн хувьд ялгаатай хоёр үед хуваагдана хэмээн үзжээ (Төрбат 2004). Тэрээр дээрх Г.П.Сосновскийн дөрвөлжин булшны гадаад зохион байгуулалтын хувьд ангилсан ангилалын 1-р төрлийг “Хэрлэнгийн төрлийн булш”, 2-р төрлийг “Туул”-ын хэлбэрийн булштай дүйнэ хэмээгээд он цагийн хувьд МЭӨ XIII-VIII, МЭӨ VIII-IV зуунд холбогдуулах санал гаргажээ. Эцэст нь тэрээр

дөрвөлжин булшны гадаад хэлбэр төрх өндөр чулуун хашлагатай, 4 буландаа гозгор чулуутайгаас намхан дөрвөлжин хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараастай болж хөгжсөн байна (Төрбат 2004) хэмээн тодорхойлжээ.

Оршуулгын зан үйл. Улаанзуухад 2008-2011 онд орших хүрлийн үеийн 20 гаруй булш малтан судалснаас 2009 онд нэг эгнээгээр орших 5 булш (Булш А, В, С, D, E) , 2010 онд хамгийн баруун эгнээний 1, 2, 3, 3а, 4, 5, 6-р булш, 2011 онд 2 дахь эгнээний 7 ба 8-р булш болон эдгээр хоёр эгнээнээс зайдуу орших 4 булш, мөн Улаанзуухаас баруун тийш холгүй орших Адгийн голд байх хүрлийн үеийн булшнуудаас хоёр булш малтан судаллаа. Дээрх хоёр газарт орших дурсгалын малтлага судалгаанаас үзвэл талийгаачийг гүн бүс нүхэнд толгойг нь ялимгүй зүүн хойт зүг чиглүүлэн, гарыг нь их биеийг дагуулан сунган тавьж түрүүлгэ харуулан тэнгэр байдлаар оршуулдаг нийтлэг зан үйл тодорхой харагдаж байна.

Улаанзуухын нэг эгнээний залгаа булшнуудаас гарсан антропологийн олдворуудын нас хүйсийг харьцуулахад булшнуудын байрлал болон нас хүйсийн эрэмбэ, дараалалд оршуулгын зан үйлийн тодорхой зүй тогтол ялгаа ажиглагдахгүй байна (Хүснэгт 1). Харин зарим булшны антропологийн олдворын дээжид үнэмлэхүй он цагийг тогтоох C^{14} шинжилгээг хийлгэхэд дараах үр дүр гарлаа (Хүснэгт 2). C^{14} шинжилгээний дүнгээс харахад (2σ хүрээнд) 2009 онд малтан судалсан нэг эгнээний таван булш (А, В, С, D) МЭӨ 1423-1385 жилийн хооронд үйлдэгдсэн оршуулга бөгөөд хамгийн түрүүчийнх болон сүүлчийн оршуулга хоёрын хооронд 38 жилийн зааг харагдаж байна. Эдгээрээс хамгийн түрүүчийн оршуулга нь Булш - В (МЭӨ 1423 жилийн тэртээх), сүүлчийнх нь Булш - D (МЭӨ 1385 жилийн тэртээх) байлаа. Энэхүү эгнээний залгаа дөрвөн булшны үнэмлэхүй он цагийг харьцуулахад Булш – В -гээс Булш - А найман жилийн дараа, Булш – А -гаас Булш - С 14 жилийн дараа, Булш - С-ээс Булш - D 24 жилийн дараа тус тус үйлдэгджээ (Хүснэгт 2). 2010-2011 онд судалсан эгнээний нийт 8 булшнаас 2010 онд малтсан гурван булшны үнэмлэхүй он цагийг тогтооход (Хүснэгт 2) хамгийн эртнийх нь 6-р булш (МЭӨ 1491 жил), дараах нь 2-р булш (МЭӨ 1443 жил), 3-р булш 1379 жил буюу хожуу үеийн оршуулга байлаа. C^{14} шинжилгээний дүнгээс харахад нэг эгнээ залгаа булшууд өөр хоорондоо цаг хугацааны хувьд 8-24 жилээр зааглагдаж байгаа нь нэлээд сонирхолтой бөгөөд нэг эгнээн дэх оршуулгууд нь нэг ураг төрлийнх, эсвэл нэг бүлийн хүмүүсийнх байж болох талтай. Гэхдээ энэхүү таамаглалыг батлахын тулд булш бүрийн антропологийн олдворын ясны ДНХ тодорхойлох шаардлага гарч байна.

Сүүлийн жилүүдэд манай орны хүрэл зэвсгийн үеийн археологийн дурсгалуудад нас барагчаа түрүүлгэ нь харуулан оршуулсан тохиолдол цөөнгүй илэрсээр байна. Хүнийг түрүүлгээ харуулан оршоосон оршуулга Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулнаа удаа дараалан малтсан таван шоргоолжин буюу хэлбэрт булшнаас (Новгородова 1989), мөн уулын баруун урд орших Хад үзүүрт малтсан шоргоолжин болон “Дөрөө” хэлбэрийн булшнаас, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Баруун Гялаатад малтсан нэг шоргоолжин булш болон замын бууц

1-р булшнаас (Эрдэнэбаатар, Ковалев 2009), Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Умдаан голын хэлбэрт булшнаас (Цэвээндорж 2005), Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд малтсан нэг шоргоолжин булшнаас (Түмэн нар, 2008), Өмнөговь аймгийн Ухаа худагт малтсан дугуй чулуун дараастай булш (Амартүвшин нар 2008), Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уулнаа малтсан дөрвөлжин чулуун хашлагатай найман булшинд (Амартүвшин нар 2007), Говь алтай аймгийн Улаанбоомын хавцалд (Цэвээндорж 2005), Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулууны Бага Монголын 1-р хэлбэрт булш, Дунд шандын 1-р булшнаас (Амартүвшин 2008) тус тус илрээд байна.

Хүснэгт 1. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан Уул, Улаанзуух дахь хүрлийн үеийн булшнаас олдсон антропологийн олдворын нас, хүйс

Малтлага хийсэн он	Булшны дугаар	Антропологийн олдворын хүйс	Антропологийн олдворын нас
2009	A	Эрэгтэй	Ахимаг нас (Maturus)
	B	Хүүхэд	5-6 нас (Infantilis II)
	C	Хүүхэд	7-8 нас (Infantilis II)
	D	Хүүхэд	5 орчим нас (Infantilis II)
	E	Тахилгын байгууламж	
2010	1	Эмэгтэй	Залуувтар эмэгтэй (Early adultus)
	2	Эмэгтэй ?	Өсвөр нас (Juvenilis)
	3	Эрэгтэй	Adultus
	3a	Эмэгтэй ?	Залуухан (Early adultus)
	4	Эрэгтэй	Ахимаг нас (Maturus)
	5	Эмэгтэй	Идэр нас (Adultus)
	6	Эрэгтэй	Ахимаг нас (Maturus)
2011	7	Эрэгтэй	Идэр нас (Adultus)
	8	Эрэгтэй	Идэр нас (Adultus)

Хүснэгт 2. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан Уул, Улаанзуух дахь хүрлийн үеийн булшнаас олдсон антропологийн олдворуудын үнэмлэхүй он цаг*

表2. 暦年較正結果

試料名	補正年代 (BP)	暦年較正年代(cal)						相対比	Code No.
		σ	cal BC 1,408 - cal BC 1,370	cal BC 1,356 - cal BC 1,316	cal BP 3,357 - 3,319	cal BP 3,305 - 3,265	0.495 0.505		
AT-788	3,082 ± 31	σ	cal BC 1,423 - cal BC 1,288	cal BC 1,283 - cal BC 1,269	cal BP 3,372 - 3,237	cal BP 3,232 - 3,218	0.970 0.030	IAAA-103368	
		2σ	cal BC 1,419 - cal BC 1,374	cal BC 1,340 - cal BC 1,319	cal BP 3,368 - 3,323	cal BP 3,289 - 3,268	0.710 0.290		
AT-789	3,101 ± 30	σ	cal BC 1,435 - cal BC 1,299	cal BC 1,386 - cal BC 1,298	cal BP 3,384 - 3,248	cal BP 3,335 - 3,247	1.000 1.000	IAAA-103369	
		2σ	cal BC 1,409 - cal BC 1,260	cal BC 1,227 - cal BC 1,222	cal BP 3,358 - 3,209	cal BP 3,176 - 3,171	0.992 0.008		
AT-790	3,054 ± 29	σ	cal BC 1,370 - cal BC 1,356	cal BC 1,316 - cal BC 1,255	cal BP 3,319 - 3,305	cal BP 3,265 - 3,204	0.097 0.692	IAAA-103370	
		2σ	cal BC 1,385 - cal BC 1,441	cal BC 1,325 - cal BC 1,192	cal BP 3,334 - 3,390	cal BP 3,274 - 3,141	0.195 0.767		
AT-791	3,015 ± 28	σ	cal BC 1,370 - cal BC 1,356	cal BC 1,316 - cal BC 1,255	cal BP 3,319 - 3,305	cal BP 3,265 - 3,204	0.097 0.692	IAAA-103371	
		2σ	cal BC 1,385 - cal BC 1,441	cal BC 1,325 - cal BC 1,192	cal BP 3,334 - 3,390	cal BP 3,274 - 3,141	0.195 0.767		
AT-821	3,127 ± 29	σ	cal BC 1,437 - cal BC 1,386	cal BC 1,491 - cal BC 1,479	cal BP 3,386 - 3,335	cal BP 3,440 - 3,428	1.000 0.020	IAAA-103372	
		2σ	cal BC 1,456 - cal BC 1,369	cal BC 1,358 - cal BC 1,315	cal BP 3,405 - 3,318	cal BP 3,307 - 3,264	0.840 0.140		
AT-822	3,006 ± 30	σ	cal BC 1,367 - cal BC 1,361	cal BC 1,314 - cal BC 1,210	cal BP 3,316 - 3,310	cal BP 3,263 - 3,159	0.038 0.956	IAAA-103373	
		2σ	cal BC 1,379 - cal BC 1,336	cal BC 1,322 - cal BC 1,187	cal BP 3,328 - 3,285	cal BP 3,271 - 3,136	0.128 0.770		
AT-823	3,115 ± 28	σ	cal BC 1,183 - cal BC 1,154	cal BC 1,146 - cal BC 1,130	cal BP 3,132 - 3,103	cal BP 3,095 - 3,079	0.059 0.043	IAAA-103374	
		2σ	cal BC 1,429 - cal BC 1,383	cal BC 1,333 - cal BC 1,324	cal BP 3,378 - 3,332	cal BP 3,282 - 3,273	0.887 0.113		

1)計算には、RADIOCARBON CALIBRATION PROGRAM CALIB REV6.0(Copyright 1986-2010 M Stuiver and PJ Reimer)を使用。

2)計算には表に示した丸める前の値を使用している。

3)1桁目を丸めるのが慣例だが、暦年較正曲線や暦年較正プログラムが改正された場合の再計算や比較が行いやすいように、1桁目を丸めていない。

4)統計的に真の値が入る確率は σ は68%、 2σ は95%である。

5)相対比は σ 、 2σ のそれぞれを1とした場合、確率的に真の値が存在する比率を相対的に示したものである。

• *Тайлбар:*

2009 онд малтан судалсан були:

AT-788- Були А; AT-789-Були-В; AT-790-Були-С; AT-791- Були-Д

2010 онд малтан судалсан були:

AT-821- Були-6; AT-822-Були-3; AT-823-Були-2.

Дээр дурьдснаас үзвэл түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулга нь Монгол орны Говь-Алтай (1 булш), Баянхонгор (2 булш), Өвөрхангай (7 булш), Өмнөговь (2

* Улаанзуухны олдворын C¹⁴ шинжилгээг Японы Palynsurvey Co.Ltd - ийн лабораторид хийлгэсэн болно .

булш), Дундговь (2 булш), Дорноговь (8 булш), Сүхбаатар (20 булш)¹ аймгуудын нутгаас олдсоныг судлаачид хэвлэн нийтлүүлсэн ба ойролцоогоор 47 тохиолдол байна. Эдгээрээс дийлэнх нь шоргоолжин (буюу Хэлбэрт) булш болох бөгөөд дөрвөлжин булш 3, дугуй дараастай, дөрвөлжин хашлагатай булш 8, дугуй хэлбэрийн булш 4, дөрөө хэлбэрийн нэг булш, Улаанзуух хэлбэрийн булш 20 судлагджээ.

Ийм төрлийн оршуулгын зан үйлийг тусгайлан судалсан судлаачид ховор бөгөөд энэ нь түрүүлгэ харуулан оршуулах оршуулга олноор олдоогүй байсантай холбоотой бололтой.

Археологич Ч.Амартүвшин, Ч.Ерөөл-Эрдэнэ, Б.Гүнчинсүрэн, Б.Цогтбаатар нар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Чандмань Хар уулнаа хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан дугуй хэлбэртэй дөрвөлжин хашлагатай найман булш малтан судалсан ба түүнийхээ хэрэглэгдэхүүнийг Монгол, Өвөр Байгальд малтан судалсан хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан оршуулгуудтай харьцуулан, холбогдох угсаатны зүйн мэдээ баримтуудыг дурьдан ёс бусаар буюу онцгой тохиолдлоор нас барсан хүнийг оршуулах хэлбэр байжээ хэмээн үзсэн байна (Амартүвшин нар 2007). Тэдгээр булшуудыг судлаачид хүрлийн эхэн үе, магадгүй, Энеолитийн үед холбогдох бололтой хэмээжээ. Мөн тэд БНХАУ-н Цзянсу мужийн Юйдуны неолитийн соёл Ючиный Цинльньчаны 25 булшны 23-т нь ийм зан үйл байдаг тухай дурьдсан байна.

Археологич Д.Эрдэнэбаатар “Тэвшийн соёл” хэмээх нэр томъёог гарган тавьж, дотор нь “шоргоолжин” болон “дөрөө” хэлбэрийн оршуулгын байгууламжийг багтаагаад ... “дөрөө” хэлбэрийн булш гэж нэрлэж байгаа булшны оршуулгын зан үйл, “шоргоолжин” хэлбэрийн булшинд хүнээ түрүүлгэ нь харуулж тавьсан байгаатай ижил зан үйлтэй учраас уг дурсгал “Тэвшийн соёл”-д хамаарна гэдгийн давхар баталгаа болно... хэмээн үзээд түрүүлгэ нь харуулан оршуулах зан үйл нь “дөрөө” болон шоргоолжин булшийг нэгэн соёлын хүрээнд багтаан үзэх нэгэн үндэслэл хэмээн үзжээ (Эрдэнэбаатар, Ковалев 2009).

Гэхдээ дээр дурьдсан булшууд нь Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Улаанзуух, Адгийн голд бидний малтан судалсан гадаад хэлбэрийн хувьд шоргоолжин (хэлбэрт) булш болон “дөрөө” хэлбэрийн булшаас эрс ялгаатай бөгөөд зөвхөн хүнээ түрүүлгэ нь харуулан оршуулсан байдгаараа ижилсдэг.

Судалгаанаас үзвэл түрүүлгэ нь харуулан оршуулах нь шоргоолжин (хэлбэрт) булшны гол онцлог зан үйл гэдгийг судлаачид удаа дараалан тэмдэглэсээр ирсэн хэдий ч Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Улаанзуух, Адгийн голд орших гадаад зохион байгуулалт нь хавтгай чулууг хэвтээгээр давхарлан, дөрвөлжлөн өрсөн өрлөгтэй булшны тухай тэмдэглэгдээгүй

¹ Энэ нь МУИС-ийн “Дорнод Монгол” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт 2008, 2009, 2010 онуудад малтсан 20 булш болно.

ажээ. Үүнээс гадна энэхүү зан үйл нь хамрах бүс нутаг, он цагийн хувьд ойролцоо байгаа нь дөрвөлжин болон шоргоолжин (хэлбэрт) булшны соёлт хүн амын угсаа соёл, харилцан хамаадлын талаар өгүүлэх нэн чухал баримт болох боломжтой. Дөрвөлжин болон шоргоолжин булшийг судалсан судлаачид зарим нь дээрх соёлуудыг нэгэн хүрээнд (Боровка 1927; Волков 1967; Диков 1958; Киселев 1947:371; Сосновский 1928) авч үздэг бол зарим нь дөрвөлжин булш болон шоргоолжин булшны соёлыг үлдээгчдээс ялгаатай (Гришин 1980; Окладников, Кириллов 1980; Эрдэнэбаатар, Ковалев 2009; 6-8) хэмээн үздэг ажээ.

Гэтэл археологич А.Д.Цыбыктаров “шоргоолжин булш”-ны соёлыг үлдээгчдийг одоо хуримтлагдсан судалгааны эх хэрэглэгдэхүүнээр бие даасан соёл мөн үү? биш үү? гэдгийг шүүн хэлэлцэх хангалттай эх сурвалж алга (Цыбыктаров 1998) хэмээн үзэж байна.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан Уулын өврийн Улаан зуух болон Адгийн голд орших хүрлийн үеийн булшны цогцолбор дурсгал нь шоргоолжин (хэлбэрт), дөрөө хэлбэрийн булшны соёлтой талийгаачийг оршуулах зан үйлийн хувьд ижил хэдий ч булшны гадаад, дотоод зохион байгуулалтаар эрс ялгаатай байгаад үндэслэн монголын хүрлийн үеийн соёлын өөр нэгэн бие даасан хэв шинж гэж үзэх болох юм.

Хүннүгийн үе

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын баруун урьд өврийн Энгэрийн бууц хэмээх аманд орших хүннүгийн 150-аад дурсгалаас амны эх, дунд хэсэг, адагт гурван булш малтан судлав. Эдгээр гурван булшны гадаад, дотоод байгууламж, оршуулгын зан үйл, малтлагаас илрэсэн олдворууд хувьд онцын ялгаа ажиглагдаагүй бөгөөд 1990-ээд оны сүүлчээр З.Батсайханы энд малтан судласан булшнуудтай адил байлаа. Гагцхүү 147-р булшнаас талийгаачийн дунд чөмөгний толгойн (анхны байдлаар ууцан доор нь тавьсан байх магадлалтай) хажуугаас хонины сээрний гурван нугалам илэрсэн болно. Талийгаачийн нуруун дор хонины гурван нуглам хойлоглон тавьж оршуулах зан үйл хожмийн Монголын үеийн оршуулгын түгээмэл зан үйл билээ.

ДҮГНЭЛТ

2008-2011 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Улаан зуухад орших хүрлийн үеийн булшны цогцолбор, Адгийн голд орших мөн үеийн булшны дурсгалын гадаад, дотоод байгууламж, олдвор, оршуулгын зан үйл адил байгаа нь уг хоёр газрын эдгээр дурсгалууд нэгэн үеийнх болох нь малтлага судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Улаанзуух, Адгийн голд орших хүрлийн үеийн эдгээр булшны дурсгал нь манай орны хүрлийн үеийн түгээмэл дурсгалын нэг болох шоргоолжин (хэлбэрт), дөрөө хэлбэрийн булшны соёлтой талийгаачийг оршуулах зан үйлийн хувьд (талийгаачийн тэргүүнийг зүүн тийш чиглүүлэн, түрүүлгэ нь харуулан оршуулах

зан үйл) ижил хэдий ч булшны гадаад, дотоод зохион байгуулалт, булшийг дагуул чулуун байгууламж хийсэн зэргээр онцлог шинжээр эрс ялгагдаж байна.

Энэ нь хүрэл зэвсгийн үед Дэлгэрхаан уул орчмын бүс нутагт орон нутгийн шинжтэй бие даасан нэгэн хэв шинж (Улаан зуухынхэв шинж) оршин байсныг харуулаж байна гэж үзэх боломжтой юм.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын өвөрт орших Улаанзуух, Адгийн гол, Булгын эх зэрэг гурван газарт төвлөрсөн гадаад байгууламжаараа ижил нийт 420 гаруй дурсгалын бүртгэгдээд байгаа болно. Цаашид энэ бүсэд орших хүрлийн үеийн энэхүү өвөрмөц дурсгалын малтлага судалгааг улам өргөжүүлэн гүнзгийрүүлэх, булшны цогцолбор болон түүний дагуул чулуун байгууламж хоёрын зан үйлийн холбоо, уг цогцолбор дурсгалуудыг үлдээгч хүн амын антропологи бүтэц, угсаа гарвал, нүүдэл суудал, уг дурсгалын газарзүйн тархалт зэрэг олон асуудал зэрэг нэн чухал асуудлууд урган гарч байна.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг МУИС-ийн Азийн судалгааны төв, Солонгосын ахисан түвшний судалгааны сан (KFAS)-ийн санхүүгийн дэмжлэгээр гүйцэтгэсэн болно.

Улаанзуухын антропологийн олдворт үнэмлэхүй он цаг тогтоох C14 шинжилгээг хийхэд гүн туслалцаа үзүүлсэн Японы судлаач Takehoko Daisaku болон Palynosurvey Co.Ltd компаний судлаач Hashimoto Makio, Kayai Shinji нарт талархал илэрхийлье.

Уг судалгааг гүйцэтгэхэд археологийн хээрийн шинжилгээнд оролцон ажилласан докторант Д.Хатанбаатар, Ч.Ванчигдаш, Г.Анхсанаа, магистрант Цогтбаатар, Очирболд, Ариунболд, Б.Ариунтулга, Б.Дашпэлжээ, Батчөдөр, археологи-антропологийн тэнхмийн 4-р ангийн оюутан Очирбат, Дөлгөөн, Саруул-Ирээдүй, Ууган-Эрдэнэ нар болон унаа хөсгөөрөө шуурхай үйлчилсэн жолооч Энхээ болон Жамсранжав нарт гүн талархал илэрхийлье.

Мөн бидэнтэй гар нийлэн хамтран ажилласан Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Түвд, Будда судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.В.Цыденовад талархал илэрхийлж цаашдын судалгааны ажилд нь өндөр амжилт хүсье.

НОМЗҮЙ

Амартүвшин Ч., Ерөөлэрдэнэ Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., 2007. Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн өвөрмөц нэгэн хэлбэр. SA. Tom (IV) XXIV. Fasc. 11, т. 141

Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Ерөөл-эрдэнэ Ч., Гантулга Ж., Амгалантөгс Ц., Жаргалан Б., 2008. Ухаа худагт хийсэн археологийн малтлага судалгааны үр дүн. SA. Tom (VI) XXVI. Fasc. 11.xx. 213-234

Батсайхан З. 2002. Хүннү. УБ

Боровка Г.И., 1927. Археологическое обследование среднего течения р. Толы. Северная Монголия. Вып. II. Л.ст. 61-62

Волков В.В. 1967. Бронзовый и ранний железный век Северной Монголии. УБ.

Гришин Ю.С., 1980. О фигурных плиточных могилах Забайкалья и Монголии. КСИА. Вып. 162. 12-15

- Диков Н.Н., 1958. Бронзовый век Забайкалья. Улан-Удэ., ст. 12-15
- Киселев С.В. 1947. Монголия в древности. Известия АН СССР. Том. IV. Вып. 4. М.
- Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., Түмэн Д., 2008. “Дорнод монгол” төслийн хүрээнд 2008 онд хийж гүйцэтгэсэн археологийн хээрийн судалгаа. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, ISSN 1810-5025. Vol. 4, № 1(312) December 2008.
- Наваан Д., Түмэн Д. Эрдэнэ М. Хатанбаатар Д. Анхсанаа Г. 2009. “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэсэн археологийн судалгаа// *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, ISSN 1810-5025. Vol. 5, № 1 (344): 1-53
- Новгородова Э.А., 1989. Древняя Монголия. М.
- Окладников А.П., Кириллов И.И., 1980. Юго-Восточное Забайкалье в эпоху камня и ранней бронзы. Новосибирск.
- Сосновский Г.П., 1928. Фигурные могилы. Материалы. Архив Г.П.Сосновского. Архив. ИИМК. АН. Ф-42. №251. (дам ишлэв)
- Сосновский Г.П., 1941. Плиточные могилы Забайкалья.ТОИПК ГЭ.1941.Т1
- Төрбат Ц., 2004. Эрдэнэхайрхан уулын булш ба дөрвөлжин булшны соёлыг үечлэх асуудалд. АН. Том V. Fasc. 1.
- Түмэн Д., Наваан Д., Эрдэнэ М., Хатанбаатар Д., 2008. Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан толгойд хийгдсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. МУИС-ийн Археологи-Антропологийн Тэнхмийн ГБСХ
- Түмэн Д.;Эрдэнэ М.; Хатанбаатар Д.; Анхсанаа Г., Ванчигдаш Ч., 2010. “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2010 онд хийж гүйцэтгэсэн археологийн судалгаа// *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, ISSN 1810-5025. Vol. 6, № 1 (365): 167-215
- Хатанбаатар Д., 2010. Дорнод Монголын дөрвөлжин булш. “Монгол болон Байгалын Сибирийн эртний соёл. ОУЭШ-ний хурлын хураангуй, Улаан-Удэ, Буриад, ОХУ
- Цэвээндорж Д.,Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Батболд Н., Ерөөл-Эрдэнэ Ч., Базаргүр Д., Болорбат Ц., Гантулга Ж., 2005. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь “Айвенхоу Майнз Монголия Инк” компаний ашиглалтын талбайд хийсэн малтлага судалгааны ажлын тайлан. ШУА, АХ ГБСХ. УБ
- Цыбиктаров А.Д., 1998. Культура плиточных могил Монголии и Забайкалья. Улан-Удэ. Ст. 126-128
- Эрдэнэбаатар Д., Ковалев.А.А., 2009. Тэвшийн соёл. УБИС. НУФ. Нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний бичиг. 4(3) т.в 6-8
- Tumen D., Erdene M., Khatanbaatar D., Ankhsanaa G., Vanchigdash Ch., East Mongolia Archaeological project. In: Asia research network, ISSN No: 1738-625X. Winter 2011. Vol. 8, No. 4. p. 37-38.

SUMMARY

Tumen D., Erdene M., Khatanbaatar D., Ankhsanaa G., Tsydenova N.V.

ARCHAEOLOGICAL FIELDWORK IN THE EASTERN MONGOLIA IN 2011

The archaeological crew from the Department of Archaeology and Anthropology, NUM carried out archaeological excavation and survey in Delgerkhaan mountain region, Tuvshihshiree soum, Sukhbaatar aimag. During the fieldwork season in 2011 the crew excavated seven graves in Ulaanzuukh site, two graves from Bronze age in Adgiin gol site, four graves from Xiongnu and Mongolian periods in Engeriin gol site.

The results of the excavations of rectangular shaped graves in Ulaanzuukh and Adgiin gol sites show that external and internal constructions, artifacts, and burial ritual and tradition in these two burial sites are very similar. Results of C^{14} analysis of the grave findings from Ulaanzuukh and Adgiin gol sites show these grave complexes belong to the same historical period 1300-1400 BC or Early Bronze age.

Grave monuments of these sites totally differ from other grave monuments from Bronze Age, such as slab and figured graves by its burial ritual (with the deceased laid face down), findings (pottery, beads) and surface and underground constructions. Based on the distinct features of the grave monuments in Ulaanzuukh site we conclude that during Early Bronze Age, this region was inhabited by the population with distinctive local culture, which we call “Ulaanzuukh type” of the Early Bronze Age cultures of Mongolia.

Хүснэгт 3. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дээлгэрхаан уулын Улаанзууханд орших хүрлийн үеийн булшны малтлагаас илэрсэн олдворын жагсаалт

Д/д	Булшны дугаар	Олдворын нэр	Фото зураг	Товч тодорхойлолт
1.	Булш 7	Цагаан сувс		Цагаан өнгийн сувс: Нийт 11 ширхэг. Бүгд цагаан өнгөтэй, голдоо нүхтэй дугуй хэлбэртэй. Харилцан адилгүй хэмжээтэй. Хамгийн зузаан сувсны өргөн 0.5 см. Хамгийн нимгэн сувсны зузаан 0.2 см, диаметр 0.4 - 0.6 см. Цагаан өнгийн зөөлөн эдээр засаж хийсэн гоёл чимэглэлийн зориулалттай зүйл бололтой.
2.	Булш 8	Вааран эдлэлийн хагархай		Улаан зуухын 8-р булшнаас том бага нийлсэн нийт 8 ширхэг вааран савны хагархай илэрсэн бөгөөд нэг төрлийн вааран савны хагархай хэсгүүд ажээ. 1. Саарал өнгийн вааран тогооны амсрын харьцангуй сайн хадгалагдаж үлдсэн 2 ш хагархай. Эхнийх нь 8.5x9 см хэмжээтэй. Тус вааран сав нь хүзүү гэх зүйлгүй агаад вааран савны уруулаас доош 7.2 см ээс доош битүү сараачмал хээ үргэлжилж байна. Зузаан 0.9 см орчим.




3.	Булш 8	Вааран эдлэлийн хагархай		<p>Саарал өнгийн вааран тогооны ёроолын хэсэг. 6 см орчим өндөртэй, зузаан 0.8 см орчим. Битүү сараачмал хээтэй. Тус вааран тогооны амсар, бөөр болон ёроолын хэсэг хоорондоо эвээрээ таарч нийлэхгүй байгаа хэдий ч уг ваарны амсраас доош 7 орчим см эхлэн савны ёроол хүртэл битүү самнаа хээг хээлж гаргасан болох нь дээрх хагархай хэсгүүдээс тодорхой харагдах ажээ. Нарийн ширхэгтэй шавраар хийсэн хавтгай ёроолтой вааран тогоо ажээ. Гадна болон дотор талд ямар нэгэн галд өртсөн гэх шинж тэмдэггүй.</p>
4.	Булш 8	Вааран эдлэлийн хагархай		<p>Саарал өнгийн нимгэн вааран савны хүзүүний хагархайн хэсэг 4 ш байна. Бүх хэсгүүдэд самнаа хээ тодорхой харагдаж байна.</p>

“ДОРНОД МОНГОЛ-2010, 2011” АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА

5.	Булш 8	Вааран эдлэлийн хагархай		<p>Тус ваарны суурь буюу ёроолын хэсгээс хамгийн том хэмжээтэй хадгалагдаж үлдсэн хэсэг. Битүү самнаа хээ бүхий. Суурийн диаметрийн хэмжээг сэргээн үзвэл ойролцоогоор 13 см орчим суурьтай цүлхэн вааран тогоо байсан бололтой.</p>
6.	Булш 62	Вааран эдлэлийн хагархай		<p>Уг булшнаас нийт 4 төрлийн вааран савны хагархай илэрсэн болно.</p> <p>1. Улаан хүрэн өнгийн нимгэн ваарны хагархайн бөөрөн хэсэг. Том бага нийлсэн нийт 26 ширхэг байна. Бүгд ямар нэгэн хээ чимэглэлгүй агаад дотор талдаа хөө тортогтой шатаалт муутай хагархай хэсгүүд.</p>

7.	Булш 62	Вааран эдлэлийн хагархай		<p>2. Улаан өнгийн вааран савны амсар хэсгийн хагархай 2 ш. Тэгш амсартай вааран сав байсан аж. Бүдүүн шавраар муу шатаан хийсэн бүдүүлэг вааран тогооны амсар хэсгүүд байна. Зузаан 1.4 см. Амсраас доош 2 см өргөнтэй товгор хүрээ гаргаж түүн дотроо бүдүүн ташуу зураасыг хээлэн гаргажээ.</p>
8.	Булш 62	Вааран эдлэлийн хагархай		<p>3.Саарал өнгийн вааран тогооны амсрын хагархай. 5x6 см хэмжээтэй. Амсрын тойргоос үзвэл нэлээд том хэмжээний вааран тогоо байсан болох нь илэрхий агаад гадна хэсгээрээ хөө тортог болсон харагдана. Хүзүү орчмын зузаан 0.8 см, амсрын зузаан 1.4 см. Дээд ирмэгээс 2 см орчим өргөнтэй хүрээ гарган өндөрлөж, амсрыг үүсгэжээ. Элдэв хээ чимэглэлгүй цулгуй вааран тогоо байсан бололтой.</p>



Хүснэгт 4. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Энгэрийн бууцад орших хүннүгийн үеийн булшны малтлагаас илэрсэн олдворын тодорхойлолт

Д/д	Булшны дугаар	Олдворын нэр	Фото зураг	Товч тодорхойлолт
1.	Булш 20	Төмөр амгай		Төмөр амгайн нэг талын чөмөг. 2 талдаа дугуй гархитай. Сайн хадгалагдсан. Урт 11 см. Чөмөгний өргөн 0.6 см.
2.	Булш 20	Төмөр эдлэл		Төмөр эдлэлийн үлдэгдэл 2 ш. Нийлүүлэн үзвэл зузаан цагариг хэлбэртэй зүйл болно. Маш муу хадгалагдаж төмрийн баасанд ихэд идэгджээ. Ямар нэгэн цагариг хэлбэртэй зүйл байсан бололтой.
3.	Булш 20	Төмөр эдлэл		Төмөр амгайн чөмөгний хэсэг байсан бололтой. 2 талын цагариг гогцоо сэтэрсэн байна. Одоо байгаа урт 10.4 см. Муу хадгалагдсан.

4.	Булш 20	Төмөр эдлэл		Хагас цагариг хэлбэрийн төмөр эдлэл 4 ш. Муу хадгалагдсан учраас зориулалтыг тодорхойлоход бэрхшээлтэй байна. Хагас хэсэг нь хугаран алга болжээ.
5.	Булш 20	Төмөр хутга		Төмрөөр хийсэн урт хутга. Одоо байгаа урт 12.2 см. Өргөн 2.2 см. Зарим хэсэгт нь модон бариулын ул мөр үлдэж хоцорчээ.
6.	Булш 20	Төмөр эдлэл		Дөрвөлжин хавтгай төмөр эдлэл. нэг талруугаа ялимгүй хотгор. 6x3.3 см хэмжээтэй. Бүсний арал байж болзошгүй. Гадна буюу нүүрэн хэсэгт нь даавуун эдлэлийн ул мөр мэдэгдэнэ.

“ДОРНОД МОНГОЛ-2010, 2011” АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА

7.	Булш 20	Вааран савны хагархай		Улаан хүрэн өнгийн бүдүүлэг хийцийн вааран савны бөөр хэсгийн хагархай 5 ш. Зузаан 1 см.
8.	Булш 141	Вааран савны хагархай		Улаан хүрэн өнгийн вааран савны хагархай 9 ш. Үүнд тус савны ёроолын хэсэг 1, хүзүүний хэсэг 1 бусад нь бөөр орчмийн хэсгүүд ажээ. Ямар нэгэн хээ чимэглэлгүй бүдүүлэг хийцтэй ажээ.

9.	Булш 147	Вааран савны хагархай		Ямар нэгэн хээ чимэглэлгүй хүрэн улаан өнгийн том бага нийлсэн 5 ш вааран савны хагархай
10.	Булш 147	Ясан эдлэл		Нимгэн хавтгай ясыг засаж хийсэн ромбо хэлбэрийн гонзгой эдлэл. Дээд ирмэгийн төв хэсэгт нүх гарган цоолсон нь сэтгэрсэн байна. Урт 5.5 см. Доод хэсгийн өргөн 2.4 см. Дээд хэсгээрээ 1 см.



Зураг 18. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 7 ба 8-р бүлш, тэдгээрийн дагуул чулуун байгууламж



Зураг 19. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 7-р бүлш



Зураг 20. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 8-р бүлш



Зураг 21. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 21-р булш



А.

Б.

Зураг 22. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 62-р булш

А. Гадаад зохион байгуулалт, Б. Оршуулга



Зураг 23. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзүүх, 63-р булш



Зураг 23. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Улаанзуух, 66-р булш



Зураг 24. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Адгийн гол, 21-р булш



А.

Б.

Зураг 25. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Адгийн гол, 23-р булш

А. Гадаад зохион байгуулалт, Б. Булшны нүхний дараас



А.



Б.

Зураг 26. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн дурсгал. 20-р булш.

А. Гадаад байгууламж, Б. Дотоод байгууламж чулуун авс



Зураг 26. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга. 141-р булш



Зураг 27. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Энгэрийн бууц, Хүннүгийн үеийн оршуулга, 147-р булш